



2026 оны 3 дугаар сарын 18

Багануур дүүрэг

“Багануур үйлдвэрлэл технологийн парк” ХК

Хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл журам.

12 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

12.1.Холбогдох хуульд заасан эрх бүхий байгууллага паркийн үйл ажиллагаанд дараах зөрчил илэрсэн талаар дүгнэлт гаргасан бол тухайн хуулийн этгээдэд олгосон тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай саналаа төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

12.1.1.Паркийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа эрхлээгүй болон төлөвлөгөөнд зааснаас өөр үйл ажиллагаа эрхэлсэн;

12.1.2.Төрөөс үзүүлсэн дэмжлэгийг зориулалтын бусаар ашигласан;

12.1.3.Гэрээнд заасан хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үйл ажиллагаа эхлээгүй;

12.1.4.Хууль болон гэрээнд заасан бусад тохиолдолд.

12.2.Энэ хуулийн 12.1 дэх хэсэг, эсхүл Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд заасныг үндэслэн энэ хуулийн 7.1.2-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

12.3.Энэ хуулийн 17 дугаар зүйл, эсхүл Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 7.1.2-т заасны дагуу хүчингүй болгоно.

12.4.Энэ хуулийн 12.2-т заасан түдгэлзүүлсэн нөхцөл байдал арилсан бол тусгай зөвшөөрлийн хугацааг энэ хуулийн 7.1.2-т заасны дагуу сэргээнэ.

12.5.Энэ хуулийн 12.3-т заасан нөхцөл үүссэн бол төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг Зөвшөөрлийн тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн 2-т заасан хугацаа дууссанаас хойш ажлын таван өдөрт багтаан Засгийн газарт хүргүүлнэ.

12.6.Засгийн газар энэ хуулийн 12.5-д заасан асуудлыг ажлын 15 өдөрт багтаан хэлэлцэж, шийдвэр гаргана.

Мэдээлэл өгөх ажилтан:
Парк ашиглалт, дэд бүтцийн
инженер: Э.Мөнхтөр
Утас: 80904629